ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

“ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тайландын Хаант Улсын Бангкок хотноо 2023 онд баталсан “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай
Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн
нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай
хуулийн төслийн талаар

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Бүгд Найрамдах Индонез Улсын Жакарта хотноо 2006 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хуралдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 62 дугаар чуулганаар батлагдсан бөгөөд Монгол Улс тус хэлэлцээрийг 2007 оны 10 сарын 18-ны өдөр соёрхон батлагдсан.

Тус хэлэлцээр нь олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамуудыг тодорхойлсон бөгөөд оролцогч талууд тус тусын хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлбэл зохих уялдуулсан төлөвлөгөө хэлбэрээр батлагдсан. Хэлэлцээрт 22 улс гарын үсэг зурж, 12 улс соёрхон баталж, 3 улс нэгдэн орж, 2 улс хүлээн зөвшөөрч, 4 улс баталсан байна.

Тайландын Хаант Улсын Бангкок хотноо 2023 оны 09 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулсан Транс-Азийн төмөр замын сүлжээний ажлын хэсгийн 8 дахь удаагийн хуралдаанаар Исламын Бүгд Найрамдах Иран Улсын санаачилсан дараах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцээрт оруулсан. Үүнд:

1. Хэлэлцээрийн “9 дүгээр зүйл, Хавсралт II-т нэмэлт өөрчлөлт оруулах журам” гэсэнд “9 дүгээр зүйл, Хавсралт II **ба III**-т нэмэлт өөрчлөлт оруулах журам” гэж шинэ гуравдугаар хавсралтын дугаарыг нэмсэн.

2. Хавсралт 3, "Транс-Азийн төмөр замын сүлжээн дэх төмөр зам хооронд, түүнчлэн төмөр зам болон хяналтын байгууллага хооронд цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулах тухай ерөнхий зарчим" шинэ хавсралтыг нэмсэн.

Тус зарчмын зорилго нь Транс-Азийн төмөр замын сүлжээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулахтай холбоотой оролцогч талуудын зохицуулалтыг уялдуулах, цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс суурийг бий болгоход оршино. Тухайлбал, энэ асуудлаар хоёр талт болон олон талт гэрээ, хэлэлцээр байгуулах боломж бүрдэнэ.

Соёрхон батлах хэлэлцээрийн нэмэлт буюу шинэ 3 дугаар хавсралт нь 3 зүйл, 7 хэсэг, 10 заалттай бөгөөд Транс-Азийн төмөр замын сүлжээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулахад баримтлах зарчмуудыг тодорхойлсон болно.

Монгол Улс нь “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн оролцогч улсын хувьд тус хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орсноор улс хоорондын төмөр замын тээврийн баримт бичгийг цахимжуулах эрх зүйн зохицуулалтыг олон улсын практикт нийцүүлэн уялдуулж төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм.

Тухайлбал, төмөр замаар холбогдож байгаа бүх орнууд, ялангуяа гуравдагч орноос импортлох бараа, бүтээгдэхүүний талаарх зохих мэдээллийг гаалийн байгууллага ачаа ирэхээс өмнө цахимаар авч, урьдчилан хяналт хийх, эрсдэл тооцох нөхцөл бүрдэнэ. Мөн тээврийн баримт бичиг цахимд шилжсэнээр улсын хил дээр хийх гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөх, хугацааг багасгах ач холбогдолтой.

Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт “Соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Засгийн газар гаргана” гэж заасны дагуу “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т оруулсан нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулсан.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т оруулсан нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь нэг зүйлтэй байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй.

Засгийн газраас тус хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлж байсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж 75.0 хувиар дэмжигдсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг зөвшилцөн хэлэлцэж, 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлах санал хураалтад Улсын Их Хурлын 71 гишүүн оролцож 53 гишүүн зөвшөөрсөн нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-д заасны дагуу Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжээгүй үндэслэлээр хууль санаачлагчид буцаасан болно.

Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгээр дэмжигдсэн тул танилцуулж буй тус хуулийн төсөл болон хуулийн үзэл баримтлалд өөрчлөлт оруулаагүй болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайд өөрчлөгдсөн тул хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн баталсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Нарийн бичгийн дарга нарын газраас 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн OES/B/10/2026-00108 дугаар албан бичгээр тус хэлэлцээрийн шинэ 3 дугаар хавсралтыг хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг ирүүлэхийг хүссэн болно.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

БАТЛАВ:
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН

БАТЛАВ:
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД
Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ:
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Г.ТЭМҮҮЛЭН

2026 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

“ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурал “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2007 оны 10 сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

Транс-Азийн төмөр замын сүлжээнд улс хоорондын төмөр замын тээвэртэй холбоотой зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, мөн төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох үйл ажиллагааг уялдуулах үндэс суурийг бий болгох зорилгоор Тайланд Улсын Бангкок хотноо 2023 оны 09 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Транс-Азийн төмөр замын сүлжээний ажлын хэсгийн 8 дахь удаагийн хуралдаанаар Исламын Бүгд Найрамдах Иран Улсын санаачилсан хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг олонхын саналаар баталсан.

Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт “Соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Засгийн газар гаргана” гэж заасны дагуу “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т оруулсан нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлуулах шаардлагатай.

Практик шаардлага

Монгол Улс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (НҮБ-ын АНДЭЗНК)-ын гишүүн орны хувьд тус байгууллагаас баталсан бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ, конвенц, протоколд нэгдэх, бүс нутагт хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагааны хөтөлбөр, төсөл, уулзалт, семинар, хурал чуулган, сургалтад хамрагдах зэргээр “оролцогч" улсын байр суурийг хадгалж, олон улсын төмөр замын тээврийн үйл хэрэгт оролцож байна.

"Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн баталсан нэмэлт, өөрчлөлтийг Талуудын гуравны хоёр нь хүлээн авснаас хойш арван хоёр (12) сарын дараа хүчин төгөлдөр болох зохицуулалттай. НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын нарийн бичгийн дарга нарын газраас ирүүлсэн албан бичигт 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар талуудаас ямар нэгэн санал, эсэргүүцэл ирүүлээгүй тухай мэдэгдсэн.

Хэлэлцээрт "Транс-Азийн төмөр замын сүлжээний хүрээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох тухай ерөнхий зарчмууд" шинэ гуравдугаар хавсралтыг нэмсэн бөгөөд Транс-Азийн төмөр замын сүлжээнд улс хоорондын төмөр замын тээвэртэй холбоотой зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох үйл ажиллагааг цаашид уялдуулах үндэс суурийг бий болгосон.

Монгол Улсын төмөр замын тээврийн харилцаа өргөжин хөгжиж, тээврийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буй энэ үед төмөр замын тээврийг цахимжуулах эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн практикт нийцүүлэх, уялдуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай байгаа болно.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд "Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн нэмэлт өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаар манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд аливаа сөрөг үр дагавар үзүүлэхгүй, улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй.

Мөн төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох үйл ажиллагааг талуудын хүлээн зөвшөөрсөн зарчмаар зохицуулах нь бүс нутгийн хэмжээнд хэлэлцээр байгуулах эрх зүйн үндэстэй болох, улмаар хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж, цаг хугацаа, зардлыг бууруулах, олон улсын төмөр замын тээврийн найдвартай байдал, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

---oOo---

“ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАХ СУДАЛГАА

Улаанбаатар хот

2026 он

ГАРЧИГ

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

1.1. Тухайн асуудлын мөн чанар, түүний цар хүрээ

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР БУСАД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-ын дагуу тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1 дэх хэсэгт заасан үе шатын дагуу хийж гүйцэтгэлээ.

Түүнчлэн Аргачлалын 5.4.3-т заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгосон болно.

1.1. Тухайн асуудлын мөн чанар, түүний цар хүрээ

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2006 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Жакарта хотноо хуралдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 62 дугаар чуулганаар баталж, 2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улсын Их Хурал тус хэлэлцээрийг 2007 оны 10 сарын 18-ны өдөр соёрхон батлалсан.

Тус хэлэлцээр нь олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамуудыг тодорхойлсон бөгөөд оролцогч талууд тус тусын хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлбэл зохих уялдуулсан төлөвлөгөө хэлбэрээр батлагдсан. Хэлэлцээрт 22 улс гарын үсэг зурсан бөгөөд үүнээс 12 улс соёрхон баталж, 3 улс нэгдэн орж, 2 улс хүлээн зөвшөөрч, 4 улс батлаад байна.

Хэлэлцээрт 2023 онд "Транс-Азийн төмөр замын сүлжээний хүрээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох тухай ерөнхий зарчмууд" шинэ гуравдугаар хавсралтыг нэмж баталсан.

Монгол Улс нь “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн оролцогч улсын хувьд тус хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орсноор төмөр замын тээврийн харилцаа өргөжин хөгжиж, тээврийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буй энэ үед төмөр замын тээврийг цахимжуулах эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн практикт нийцүүлэх, уялдуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

“Улаанбаатар төмөр зам” ХНН нь Монгол-Хятад-Оросын хил дамнасан цаасгүй тээвэр, дамжин өнгөрөх тээврийн бүртгэл мэдээллийг цахимжуулах ажлын хүрээнд ОХУ-ын “Оросын төмөр замууд” НХН-тэй 2012 онд, БНХАУ-ын “Хятадын төмөр замууд” корпорацтай 2019 онд тус бүр гэрээг байгуулж, хил дамнасан төмөр замын олон улсын харилцааны ачаа тээврийн цахим мэдээллийг харилцан солилцох чиглэлээр ажиллаж байгаа болно. Мөн энэ асуудлаар Гаалийн ерөнхий газар, “Улаанбаатар төмөр зам” ХНН хооронд байгуулсан ажлын хэсгийг 2023 онд шинэчлэн ажиллаж байна.

Тус хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орсноор Гаалийн байгууллага, “Улаанбаатар төмөр зам” ХНН хооронд болон тэдгээрийн Орос, Хятадын талын

гаалийн байгууллага, төмөр замуудтай харилцан мэдээлэл солилцож буй үйл ажиллагааг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Хэлэлцээрийн шинэ гуравдугаар хавсралт "Транс-Азийн төмөр замын сүлжээний хүрээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох тухай ерөнхий зарчмууд"-ын зорилго нь Транс-Азийн төмөр замын сүлжээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцохтой холбоотой оролцогч талуудын зохицуулалтыг уялдуулах, цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс суурийг бий болгоход оршино.

Монгол Улс нь “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн оролцогч улсын хувьд тус хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орсноор төмөр замын тээврийг цахимжуулах эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн практикт нийцүүлэх, уялдуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм.

ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР БУСАД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Гадаад улс онуудтай төмөр замын тээврийн салбарт харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцоог нарийвчлан зохицуулсан олон улсын гэрээ байхгүй бөгөөд тус хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлт нь олон улсын төмөр замын тээврийг цахимжуулах эрх зүйн зохицуулалтын орчныг бий болгож байгаа болно.

Монгол Улс 2022 онд нэгдэн орсон “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр” нь гадаад худалдааны баримт бичгийг цахимжуулах, мэдээллийн системийн тухай ерөнхий зохицуулалтыг агуулсан байдаг.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тандан судалгаагаар “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна.

---oOo---

ХАВСРАЛТ

Хүснэгт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, харимуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	
2.Хүний эрхийг	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Үгүй	
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		

Хүснэгт 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ

	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

Хүснэгт 3

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ

мэнд, боловсролын систем	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсрролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	

Хүснэгт 4

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	

	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	

---oOo---

“ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2026 он

ГАРЧИГ

УДИРТГАЛ

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

4.2. Зөвлөмж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд хуулийн төсөлд практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох, хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх зэргээр хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлж, зөвлөмж гаргахыг заасан.

Энэ хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл (Цаашид “Хуулийн төсөл” гэх)-д уг судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгаагаар тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорьсон болно.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөг тооцохдоо тухайн боловсруулж буй хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болох тул “зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгосон.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх тул тус заалтыг сонгож, тухайн зүйл заалтын үр нөлөөг судлах болно.

Шалгуур үзүүлэлт	**Хуулийн төслийн зүйл, заалт**
Зорилгод хүрэх байдал	**1 дүгээр зүйл.** Тайландын Хаант Улсын Бангкок хотноо 2023 онд баталсан “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар сонгосон.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагаас дүгнэвэл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (НҮБ-ын АНДЭЗНК)-ын гишүүн орны хувьд тус байгууллагаас хэрэгжүүлж буй хамтын ажиллагааг бэхжүүлэх, Транс-Азийн төмөр замын сүлжээнд улс хоорондын төмөр замын тээвэртэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хуулийн төслийн зорилго чиглэгдэж байна.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас нэн түрүүнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага (хуулийн төслийн үзэл баримтлалаас)	Хуулийн төслийн зорилго
Хэлэлцээрт "Транс-Азийн төмөр замын сүлжээний хүрээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох тухай ерөнхий зарчмууд" шинэ гуравдугаар хавсралтыг нэмсэн бөгөөд Транс-Азийн төмөр замын сүлжээнд улс хоорондын төмөр замын тээвэртэй холбоотой зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох үйл ажиллагааг цаашид уялдуулах үндэс суурийг бий болгосон.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (НҮБ-ын АНДЭЗНК)-ын гишүүн орны хувьд тус байгууллагаас хэрэгжүүлж буй хамтын ажиллагааг бэхжүүлэх, олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн төмөр замын тээврийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, улс хоорондын төмөр замын тээврийн үйл ажиллагааны үр ашиг, уялдаа холбоог нэмэгдүүлэх, тээврийн үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн солилцооны нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.
Монгол Улсын төмөр замын тээврийн харилцаа өргөжин хөгжиж, тээврийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буй энэ үед төмөр замын тээврийг цахимжуулах эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн практикт нийцүүлэх, уялдуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай.	

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн үр нөлөөг “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэлээ.

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томьёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилгодоо хүрэх байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

4.2. Зөвлөмж

Хуулийн төсөл нь нэг зүйлтэй бөгөөд зорилгодоо хүрэх байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн тул хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулж батлуулахыг зөвлөмж болгов.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үр нөлөөг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхдээ дараах эх сурвалжийг ашигласан болно. Үүнд:

1. “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

2. “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал.

3. Гадаад харилцааны яамны хянан баталгаажуулсан “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийн орчуулга.

4. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт.

---oOo---

“ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2026 он

ГАРЧИГ

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан. “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-ыг баримтлан зардлын тооцоог хийв.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэнэ.

Тус хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлохдоо энэхүү хуулийн төсөл нь “нэмэлт, өөрчлөлт” хэлбэрээр бичигдэж байгаа боловч шинээр буюу өмнө нь гүйцэтгэж байгаагүй үүрэг болон өмнө гүйцэтгэж байсан боловч тухайн үүргийг хуулийн төслөөр өргөжүүлсэн байвал тэр хүрээнд хязгаарлан зардал тээгч этгээдүүдийн зардлыг тооцох болно.

Хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж байгаа үүрэг эсхүл өмнө нь хэрэгжүүлж байсан үүргийг өргөжүүлсэн үүргийн тухайн өргөжүүлсэн хэсэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2 заалтад “тохиолдлын тоо нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Ингэхдээ статистикийн тоо мэдээг ашиглах бөгөөд энэ талаар статистик тоо байхгүй бол баримжаалж тооцно", 4.4.2 дахь заалтад "зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авах бөгөөд тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтооно." гэснийг тус тус баримтлан адил төстэй ажил, үйлчилгээнд зарцуулсан хугацаа, тохиолдлын тоог баримжаалан тогтоох болно.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т холбогдох нэмэлт өөрчлөлт оруулж байгаа бөгөөд уг хэлэлцээрийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Үүний тулд соёрхон батлагдах "Транс-Азийн төмөр замын сүлжээний хүрээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох тухай ерөнхий зарчмууд" гуравдугаар хавсралтаар хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалт байгаа эсэхийг судалж үзсэн.

Тухайн хуулийн төслөөр хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцоолох эхний алхам буюу хуулийн этгээдэд үүсгэсэн үүргийг тогтоох үед хуулийн төсөл болон хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлт нь хуулийн этгээдэд үүрэг үүсгээгүй байх тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй юм.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэхгүй гэж үзлээ.

ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлт нь иргэнд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгасан эсэхийг судалж үзсэн.

Хуулийн төсөл нь нэг зүйлтэйгээр бичигдсэн бөгөөд хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтөөр төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох тухай ерөнхий зарчмуудыг тодорхойлсон.

Тухайн хуулийн төслөөр иргэнд үүсэх зардлыг тооцоолох эхний алхам буюу иргэнд үүсгэсэн үүргийг тогтоох үед хуулийн төсөл болон хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлт нь иргэнд үүрэг үүсгээгүй, иргэдэд хамааралтай зохицуулалт байхгүй тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй юм.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь иргэнд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төсөл нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т холбогдох нэмэлт өөрчлөлт оруулж байгаа бөгөөд уг төсөл болон хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд төрийн байгууллагад ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Үүний тулд соёрхон батлагдах "Транс-Азийн төмөр замын сүлжээний хүрээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох тухай ерөнхий зарчмууд" гуравдугаар хавсралтаар төрийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн заалт байгаа эсэхийг судалж үзсэн.

Тухайн хуулийн төслөөр улсын төсөвт үүсэх зардлыг тооцоолох эхний алхам буюу төрийн байгууллагад үүсгэсэн үүргийг тогтоох үед хуулийн төсөл болон хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлт нь төрийн байгууллагад үүрэг үүсгээгүй байх тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй юм.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь улсын төсөвт зардал үүсгэхгүй гэж үзлээ.

---oOo---

ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН

9 дүгээр зүйл

II ба III хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах журам

1. Энэ зүйлд заасан журмын дагуу Хэлэлцээрийн II ба III хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2. Аль ч тал нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно.

3. Санал болгосон аливаа нэмэлт, өөрчлөлтийн бичвэрийг Нарийн бичгийн дарга нарын газраас тухайн нэмэлт, өөрчлөлтийг батлах Ажлын хэсгийн хуралдаан болохоос дөчин таван (45)-аас доошгүй өдрийн өмнө Ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн байна.

4. Ажлын хэсгийн хуралдаанд оролцож, санал өгсөн Талуудын олонхын саналаар нэмэлт, өөрчлөлтийг батална. Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг Нарийн бичгийн дарга нарын газар нь бүх Талуудад хүргүүлэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хандана.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн дагуу батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг тухайн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан (6) сарын дотор Талуудын гуравны нэгээс доошгүй нь хүлээн зөвшөөрөхгүй тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдвэл нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн нэмэлт, өөрчлөлт нь энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан зургаан (6) сарын хугацаа дуусгавар болсноос хойш гурван (3) сарын дараа бүх Талуудад хүчин төгөлдөр үйлчилнэ.

---oOo---

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН
Гарын үсэг /Signature:
2024 оны 7 сарын 2 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН

III ХАВСРАЛТ

Транс-Азийн Төмөр замын Сүлжээн дэх төмөр зам хооронд, түүнчлэн төмөр зам болон хяналтын байгууллага хооронд цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулах тухай өрөнхий зарчим

I. Нийтлэг үндэслэл

1. Эдгээр зарчим нь Транс-Азийн Төмөр замын Сүлжээн дэх олон улсын төмөр замын тээвэрийн зохицуулалт болон үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс төмөр зам хооронд, түүнчлэн төмөр зам болон хяналтын байгууллага хооронд харилцан цахим мэдээлэл солилцох/өгөгдөл дамжуулах үйл ажиллагааг уялдуулах үндэс суурийг бий болгоход оршино.

2. Зарчмын үндсэн зорилго нь Транс-Азийн Төмөр замын Сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт оролцогч Талуудад цахим мэдээлэл солилцох үйл ажиллагааг харилцан уялдуулах ерөнхий удирдамжийг өгснөөр Транс-Азийн Төмөр замын Сүлжээнд олон улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

3. Эдгээр зарчим нь өргөн цар хүрээг хамрах бөгөөд эрх зүйн төрөл бүрийн дэглэм, хөгжлийн бүхий л үе шатад яваа Талууд хооронд ашиглах боломжтой тул Талууд эдгээр зарчмыг дагаж мөрдөх бүхий лхүчин чармайлтыг гаргана.

4. Эдгээр зарчим нь цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулах талаар олон улсын төмөр замын байгууллагын нэвтрүүлсэн туршлага болон боловсруулсан стандартыг Транс-Азийн Төмөр замын Сүлжээний гишүүд ашиглахыг хөхиүлэн дэмжинэ.

5. Эдгээр зарчим нь төмөр зам хооронд, түүнчлэн төмөр зам болон хяналтын байгууллага хооронд цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулах үйл ажиллагааг уялдуулахад олон талт болон бүс нутгийн хэмжээнд хэлэлцээр байгуулах үндэс суурийг бий болгоно.

II. Төмөр зам хооронд цахим мэдээлэл солилцох/өгөдөл харилцан дамжуулах

6. Хэлэлцээрийн Талуудын төмөр замын байгууллага хооронд цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

(a) Олон улсын төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааны шаардлагыг хангах үүднээс төмөр зам хооронд дараах мэдээлэлтэй холбоотой цахим өгөгдлийг солилцож болно: (i) ачааны тээврийн дагалдах бичиг; (ii) галт тэрэгний мэдээлэл; (iii) вагоны хөдөлгөөн, вагоны байршил тогтоох.

(b) Транс-Азийн Төмөр замын Сүлжээний дэх цахим мэдээлэл солилцоог хангах зорилгоор захидал (зурвас)/эсхүл цахим өгөгдлийн хэлбэр, бүтцийг олон

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Гарын үсэг /Signature/ .....
24 оны 7 сарын 2 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

улсын төмөр замын байгууллагаас нэвтрүүлсэн стандарт, туршлагыг харгалзан уялдуулж болно.

(c) Транс-Азийн Төмөр замын Сүлжээний гишүүдийн хооронд цахим мэдээлэл/өгөгдлийг саадгүй солилцоход дараах агуулга бүхий уялдуулсан зохицуулалтад суурилсан байж болно: (i) төмөр замын төрөл бүрийн системийг холбох нийтлэг интерфейсийг ашиглах; (ii) уялдах боломжтой цахим харилцааны аргууд; (iii) өгөгдлийн хамгаалалт, аюулгүй байдлын нийтлэг стандартууд.

(d) Харилцан солилцох цахим өгөгдөл болон захидал (зурвас)-ын тодорхой агуулгыг хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр тодорхойлж болно. Үүнтэй холбогдуулан, төмөр замын байгууллагаас нэвтэрүүлсэн цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулах талаар хоёр талт, олон талт загвар гэрээг ашиглаж болно.

(e) Төмөр замаар хил нэвтрэх нэвтрэх үеийн горимыг дагаж мөрдөхөд шаардагдах хугацааг бууруулах үүднээс төмөр замын байгууллаг нь галт тэрэг ирэх хугацаанаас өмнө цахим мэдээлэл солилцох, өгөгдөл харилцан дамжуулахыг хөхиүлэн дэмжинэ.

III. Төмөр зам болон хяналт шалгалтын байгууллага хооронд цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулах

7. Төмөр зам болон хэлэлцээрийн Талуудын хяналт шалгалтын байгууллагууд хооронд цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

(a) Талууд нь зохицуулагч байгуулагаас тавьж буй шаардлагыг хангах үүднээс цахим мэдээлэл солилцох/өгөгдөл харилцан дамжуулах оновчтой арга замыг хэлэлцэн тохиролцох зорилгоор төмөр зам, гааль болон хилийн бусад байгууллагын төлөөллөөс бүрдсэн тусгай зорилтот ажлын хэсэг байгуулж болно.

(b) Бүрдүүлэлтийн шаарлдагыг хангах зорилгоор төмөр замууд нь хүлээн авсан цахим мэдээлэл, өгөгдөл (6(a) зүйл заалтыг харах)-ийг гааль болон бусад хилийн байгууллагад зохих журмын дагуу цахим хэлбэрээр дамжуулж болно.

(c) Төмөр зам, гааль болон бусад хилийн байгууллага нь дотоодын эрх зүйн зохицуулалтад нийцсэн, ачааны дагалдах бичгийг гаалийн баримт бичиг гэж хүлээн зөвшөөрөх боломжтой байдал зэрэг цахим хэлбэрээр солилцох өгөгдөл мэдээлэл/өгөгдөл, холбогдох горимыг тодорхой тусгасан харилцан ойлголцлын санамж бичиг эсхүл түүнтэй төстэй эрх зүйн баримт бичгээр дамжуулан байгууллага хоорондын гэрээнд нэгдэн орж болно.

(d) Төмөр зам болон гаалийн байгууллага нь зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, өгөгдлийг солилцох уялдуулсан цахим интерфейсийг боловсруулж болно.

(e) Боломжит бүхий л тохиолдолд шинэ технологи болон интрузив бус шалгалтын аргыг ашиглан хилийн төмөр замын боомтууд дахь хилийн дамжуулах өртөөн дээр хөдлөх бүрэлдэхүүн, бараа бүтээгдэхүүний талаарх мэдээллийг, өгөгдлийг цахим хэлбэрээр цуглуулж, төмөр зам, хил болон гаалийн байгууллага хооронд мэдээлэл, өгөгдлийг зохих ёсоор солилцох шаардлагатай.

Signature
2024 оны 7 сарын 2-өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

UNITED NATIONS NATIONS UNIES

POSTAL ADDRESS—ADRESSE POSTALE: UNITED NATIONS, N.Y. 10017

Reference: C.N.518.2023.TREATIES-XI.C.5.a (Depositary Notification)

AMENDMENTS TO THE MAIN TEXT OF THE INTERGOVERNMENTAL AGREEMENT ON THE TRANS-ASIAN RAILWAY NETWORK

BANGKOK, 15 SEPTEMBER 2023

ADOPTION OF AMENDMENTS TO THE MAIN TEXT OF THE AGREEMENT

The Secretary-General of the United Nations, acting in his capacity as depositary, communicates the following:

At its eighth meeting, held in Bangkok and online on 14 and 15 September 2023, the Working Group on the Trans-Asian Railway Network adopted amendments, proposed by the Islamic Republic of Iran, to the main text of the Agreement in accordance with its Article 7.

The procedure for amending the main text of the Agreement is set forth in its article 7 which reads as follows:

"1. The main text of this Agreement may be amended by the procedure specified in this Article.

2. Amendments to this Agreement may be proposed by any Party.

3. The text of any proposed amendment shall be circulated to all members of the Working Group by the secretariat at least forty-five (45) days before the Working Group meeting at which it is proposed for adoption.

4. An amendment shall be adopted by the Working Group by a two-thirds majority of the Parties present and voting. The amendment as adopted shall be communicated by the secretariat to the Secretary-General of the United Nations, who shall circulate it to all Parties for acceptance.

5. An amendment adopted in accordance with paragraph 4 of the present Article shall enter into force twelve (12) months after it has been accepted by two-thirds of the Parties. The amendment shall enter into force with respect to all Parties except those which, before it enters into force, declare that they do not accept the amendment. Any Party that has declared that it does not accept an amendment adopted in accordance with this paragraph may at any time thereafter deposit an instrument of acceptance of such amendment with the Secretary-General of the United Nations. The amendment shall enter into force for that State twelve (12) months after the date of deposit of the said instrument."

***

The texts of the adopted amendments in the Chinese, English and Russian languages are contained in the annex to this notification.

21 December 2023

C.N.518.2023.TREATIES-XI.C.5.a

Annex/Annexe

Amend Article 9 of the Agreement as follows (new text is indicated using grey bold font):

Article 9

Procedures for amending annexes II and III

1. Annexes II and III to the Agreement may be amended by the procedure specified in this Article.

2. Amendments may be proposed by any Party.

3. The text of any proposed amendment shall be circulated to all members of the Working Group by the secretariat at least forty-five (45) days before the Working Group meeting at which it is proposed for adoption.

4. An amendment shall be adopted by the Working Group by a majority of the Parties present and voting. The amendment as adopted shall be communicated by the secretariat to the Secretary-General of the United Nations, who shall circulate it to all Parties.

5. An amendment adopted in accordance with paragraph 4 of the present Article shall be deemed accepted if during a period of six (6) months from the date of the notification, less than one third of the Parties notifies the Secretary-General of the United Nations of their objection to the amendment.

6. An amendment accepted in accordance with paragraph 5 of the present Article shall enter into force for all Parties three (3) months after the expiry of the period of six (6) months referred to in paragraph 5 of the present Article.

Annex III

General principles on electronic information exchange/data interchange among railways and between railways and control agencies along the Trans-Asian Railway Network

I. General

1. These principles aim to provide grounds for the further harmonization of electronic information exchange/data interchange among railways and between railways and control agencies for the efficient completion of regulatory and operational requirements in international railway transport along the Trans-Asian Railway Network.

2. The main objective of the principles is to provide general guidance to the Parties to the Intergovernmental Agreement on the Trans-Asian Railway Network on harmonizing electronic information exchange practices with the overarching objective of increasing the competitiveness of international railway transport along the Trans-Asian Railway Network.

3. Parties shall make every possible effort to conform to these principles, as they are broad in scope and can be used in Parties with diverse legal regimes and at different levels of development.

4. The principles encourage the members of the Trans-Asian Railway Network to use existing standards and practices on electronic information exchange/data interchange developed by international railway organizations.

5. The principles could also serve as a basis for developing plurilateral, multilateral and regional agreements on harmonizing electronic information exchange/data interchange among railways and between railways and control agencies.

II. Electronic information exchange/data interchange among railways

6. Electronic information exchange/data interchange among railways of the Parties to the Agreement shall be guided by the following principles:

(a) For completing the operational requirements in international railway transport, electronic data related to the following information may be exchanged between railways: (i) consignment notes; (ii) train information; and (iii) movement and tracking of wagons;

(b) The structure and format of messages and/or electronic data may be harmonized taking into account existing standards and practices that have already been developed by international railway organizations to ensure electronic interoperability along the Trans-Asian Railway Network;

(c) The seamless flow of electronic information/data among the members of the Trans-Asian Railway Network could be based on a harmonized approach that could include: (i) the use of common interfaces for linking different railway systems; (ii) compatible methods for electronic communication; and (iii) common data protection and security standards;

(d) The exact content of the electronic data and messages exchanged could be determined on the basis of bilateral or multilateral agreements or arrangements. In this regard, railways may use the model bilateral or multilateral agreements for electronic information exchange/data interchange that have already been developed by railway organizations;

(e) Railways are encouraged to exchange electronic information/interchange data as early as possible, preferably before the arrival of trains, to minimize the time required to complete railway border-crossing formalities.

III. Electronic information exchange/data interchange between railways and control agencies

7. Electronic information exchange/data interchange between railways and control agencies of the Parties to the Agreement shall be guided by the following principles:

(a) Parties could establish a special task force consisting of representatives of railways, customs and other border agencies, as appropriate, to discuss and agree on optimum ways of engaging in electronic information exchange/data interchange to meet the data requirements of regulatory agencies;

(b) The electronic information and data received by railways (see para. 6 (a) above) for the completion of regulatory formalities could be shared electronicaily with customs and other border agencies, as appropriate;

(c) Railways, customs and other border agencies, as appropriate, may enter into institutional arrangements, preferably through memorandums of understanding or similar legal instruments, clearly indicating the data to be exchanged

electronically and the related modalities, including on the acceptance of consignment notes as customs documents where feasible and consistent with national regulations;

(d) Railways and customs agencies may develop a harmonized electronic interface to share data and exchange the information required for completing regulatory formalities;

(e) Wherever possible, new technologies and non-intrusive inspections at railway border crossings and border interchange stations should be used to electronically collect data and information on the rolling stock and goods, and the information and data should be shared among railways and border agencies, including customs, as appropriate.

6. Азийн авто замын замналын дугаар зарчмын хувьд гишүүн тухайн улсын замын тэмдгийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг байна. Дугаар илэрхийлсэн тэмдгийг авто замд дөхөж очих, эсхүл түүнээс гарахад өмнө нь, эсхүл хойно нь байрлуулна.

7. Хэрэв гишүүн улс Азийн авто замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын Хэлэлцээр болон Олон улсын авто замын хөдөлгөөний тухай Европын Хэлэлцээрийн аль алины оролцогч бол замналыг Азийн авто замын замналын тэмдэг болон Европын авто замын замналын тэмдгийн аль нэгийг хэрэглэх, эсхүл аливаа талын үзэмжээр хоёуланг нь хэрэглэнэ.

8. Хэрэв Азийн авто замын замнал өөр замналаар өөрчлөгдсөн буюу Азийн авто замын өөр замналыг огтолсон бол Азийн авто замын холбогдох замналуудын дугаарыг тухайн авто замд нэвтрэх буюу түүнээс гарах үед тавина.

170. ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

2006 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр баталж,
*2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон**

Хэлэлцэн тохиролцогч талууд,

Ази болон хөрш зэргэлдээ бүс нутгийн олон улсын төмөр замын тээврийг дэмжих болон хөгжүүлэх шаардлагыг ухамсарлаж,

Даяаршлын өнөөгийн үед олон улсын худалдаа өргөжин тэлсний улмаас зорчигч болон барааны олон улсын тээвэрлэлт улам нэмэгдэхийг харгалзаж,

Транс-Азийн төмөр замын сүлжээг байгуулах болон ашиглалтанд оруулахад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн улсуудын хоорондын хамтын ажиллагаа шаардлагатай гэдгийг эргэн санаж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн улсуудын хоорондын харилцааг бэхжүүлэх болон олон улсын худалдаа, аялал жуулчлалыг хөхиүлэн дэмжихийн тулд олон улсын ач холбогдолтой өртөө болон чингэлгийн терминалыг оролцуулан Транс-Азийн төмөр замын сүлжээг олон улсын тээвэрлэлт, байгаль орчныг хамгаалах шаардлагын дагуу хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж,

Төмөр замын тээврийг шуурхай, үр ашигтай олон улсын олон төрөлт тээврийн сүлжээн, ялангуяа далайд гарцгүй болон дамжин өнгөрөх улсуудын өвөрмөц хэрэгцээ шаардлагыг хангах үүрэгтэй чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг анхааран үзэж,

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл
Олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамын тодорхойлолт

Транс-Азийн төмөр замын сүлжээний талаарх Засгийн газар хоорондын хэлэлцээр (цаашид "хэлэлцээр" гэх)-ийн зорилгоор Хавсралт 1-д тодорхойлсон "олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугам" гэсэн нэр томьёо нь:

* Монгол Улс 2006.11.10-нд соёрхон баталсан

a) олон улсын байнгын тээвэрт одоо ашиглаж буй төмөр замын шугам;

b) олон улсын байнгын тээвэрт ашиглахаар зориулагдсан одоо ашиглаж буй, баригдаж буй, эсхүл барихаар төлөвлөж буй төмөр замын шугам;

c) өөр өөр улсын, эсхүл нэг улсын терминалуудын хооронд далайн, эсхүл нуурын тогтмол тээврийг хангадаг усан онгоцны гарам;

d) гаалийн шалгалтын барилга байгууламж/албад байрладаг хил нэвтрэх цэг, өөр царигтай төмөр замын уулзвар цэгүүд, усан терминал болон төмөр замтай холбосон чингэлгийн терминалыг тус тус хэлнэ.

2 дугаар зүйл

Транс-Азийн төмөр замын сүлжээг батлах

Хэлэлцэн тохиролцогч талууд (цаашид “талууд” гэх) үүгээр хэлэлцээрийн Хавсралт 1-д тодорхойлсон олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамыг талуудын үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлвэл зохих, олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамыг хөгжүүлэх үүрэгтэй талуудын уялдуулсан төлөвлөгөөний хэлбэрээр батлана.

3 дугаар зүйл

Транс-Азийн төмөр замын сүлжээг хөгжүүлэх

Транс-Азийн төмөр замын сүлжээний шугамыг энэхүү хэлэлцээрийн Хавсралт 2-т тодорхойлсон техникийн үзүүлэлтүүдэд хамаарах удирдлага болгох зарчмуудтай нийцүүлэн тодорхойлно.

4 дүгээр зүйл

Гарын үсэг зурах болон оролцогч тал болох журам

1. Энэхүү хэлэлцээрт 2006 оны 11 дүгээр сарын 10-наас 11-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хотноо, түүнээс хойш 2008 оны 11 дүгээр сарын 16-наас 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нью-Йорк дахь Төв байранд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн улсууд гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Эдгээр улс дараах хэлбэрээр хэлэлцээрт оролцогч тал болж болно. Үүнд:

a) соёрхон батлах нөхцөлтэйгээр гарын үсэг зурах, хүлээн зөвшөөрөх, эсхүл баталж дараа нь соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу батлах, эсхүл

b) нэгдэн орох.

3. Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

5 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү хэлэлцээр нь 4 дүгээр зүйлийн 2 болон 3 дугаар заалтын дагуу доод тал нь найман (8) улсын Засгийн газар хэлэлцээрт оролцогч тал болохыг зөвшөөрснөөс хойш 90 дэх өдөр хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох нөхцөлүүд бүрэлдсэнээс хойш хэлэлцээрийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл нэгдэн орсон улсын хувьд баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш 90 дэх өдрөөс энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

6 дугаар зүйл

Транс-Азийн төмөр замын сүлжээний ажлын хэсэг

1. Хэлэлцээрийн хэрэгжилт болон санал болгож буй аливаа нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх зорилгоор тулд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комисс Транс-Азийн төмөр замын сүлжээний ажлын хэсэг (цаашид "Ажлын хэсэг" гэх)-ийг байгуулна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн бүх улс тухайн Ажлын хэсгийн гишүүн байна.

2. Ажлын хэсэг хоёр жилд нэг удаа хуралдана. Аль ч тал Нарийн бичгийн дарга нарын газарт хандаж Ажлын хэсгийн тусгай хуралдааныг зарлан хуралдуулах хүсэлт гаргаж болно. Нарийн бичгийн дарга нарын газар уг хүсэлтийг Ажлын хэсгийн бүх гишүүнд мэдэгдэж, ийнхүү мэдэгдсэнээс хойш дөрвөн (4) сарын дотор талуудын гуравны нэгээс доошгүй нь тухайн хүсэлтийг зөвшөөрсөн хариу өгвөл Ажлын хэсгийн тусгай хуралдааныг зарлан хуралдуулна.

7 дугаар зүйл

**Хэлэлцээрийн үндсэн эх бичвэрт нэмэлт,
өөрчлөлт оруулах журам**

1. Энэхүү хэлэлцээрийн үндсэн эх бичвэрт энэ зүйлд заасан журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2. Аль ч тал нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно.

3. Санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн эх бичвэрийг Нарийн бичгийн дарга нарын газраас тухайн нэмэлт, өөрчлөлтийг батлах Ажлын хэсгийн хуралдаан болохоос дор хаяж дөчин таван (45) хоногийн өмнө Ажлын хэсгийн бүх гишүүнд хүргүүлнэ.

4. Ажлын хэсгийн хуралдаанд оролцож, санал өгсөн талуудын гуравны хоёрын олонхын саналаар нэмэлт, өөрчлөлтийг батална. Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг Нарийн бичгийн дарга нарын газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж, улмаар Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн зөвшөөрүүлэхээр бүх талд илгээнэ.

5. Талуудын гуравны хоёр энэ зүйлийн 4 дэх заалтын дагуу батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрснөөс хойш арван хоёр (12) сарын дараа тухайн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтийг түүнийг хүлээн зөвшөөрсөн бүх тал дагаж мөрдөх бөгөөд харин нэмэлт, өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос өмнө түүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан талуудад үйлчлэхгүй. Энэ заалтын дагуу батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан аливаа тал цаашид уг нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хэдийд ч хадгалуулахаар өгч болно. Тухайн улсын хувьд нэмэлт, өөрчлөлт уг баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш арван хоёр (12) сарын дараа хүчин төгөлдөр болно.

8 дугаар зүйл

Хавсралт 1-д нэмэлт, өөрчлөлт оруулах журам

1. Энэхүү Хэлэлцээрийн Хавсралт 1-д энэ зүйлд заасан журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2. 8 дугаар зүйлийн зорилгоор “шууд холбогдох тал” гэсэн нэр томьёо нь санал болгож буй нэмэлт, өөрчлөлт аль талын нутаг дэвсгэрт хамаарч байна тухайн талыг хэлнэ.

3. Хилийн өртөөг өөрчлөх нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн шууд холбогдох тал тухайн нэмэлт, өөрчлөлтийн нийтлэг зүйлтэй хил залгаа хөрш оронтойгоо зөвлөлдөн, түүнээс бичгээр зөвшөөрөл авсны дараа санал болгож болно.

4. Хилийн өртөөг өөрчлөхөөргүй нэмэлт, өөрчлөлтийг шууд сонирхогч аливаа тал санал болгож болно.

5. Аливаа талын санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн эх бичвэрийг Нарийн бичгийн дарга нарын газраас тухайн нэмэлт, өөрчлөлтийг батлах Ажлын хэсгийн хуралдаанаас доод тал нь дөчин таван (45) хоногийн өмнө Ажлын хэсгийн бүх гишүүнд хүргүүлнэ.

6. Ажлын хэсгийн хуралдаанд оролцож, санал өгсөн талуудын олонхын саналаар нэмэлт, өөрчлөлтийг батлана. Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг Нарийн бичгийн дарга нарын газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж, улмаар Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн зөвшөөрүүлэхээр бүх талд илгээнэ.

7. Энэ зүйлийн 6 дугаар заалтын дагуу батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг талуудын гуравны нэгээс цөөнх нь энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш зургаан (6) сарын дотор хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан хариуг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлбэл тухайн нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

8. Энэ зүйлийн 7 дахь хэсгийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн нэмэлт, өөрчлөлтийг бүх талд энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан зургаан (6) сар өнгөрснөөс хойш гурван (3) сарын дараа бүх талын хувьд хүчин төгөлдөр болно.

9 дүгээр зүйл

Хавсралт 2-т нэмэлт, өөрчлөлт оруулах журам

1. Энэхүү хэлэлцээрийн хавсралт 2-т энэ зүйлд заасан журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2. Аливаа тал нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно.

3. Санал болгосон аливаа нэмэлт, өөрчлөлтийн эх бичвэрийг Нарийн бичгийн даргын газраас тухайн нэмэлт, өөрчлөлтийг батлах Ажлын хэсгийн хуралдаанаас доод тал нь дөчин таван (45) хоногийн өмнө Ажлын хэсгийн бүх гишүүнд хүргүүлнэ.

4. Ажлын хэсгийн хуралдаанд оролцож, санал өгсөн талуудын олонхын саналаар нэмэлт, өөрчлөлтийг батлана. Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг Нарийн бичгийн дарга нарын газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж, улмаар Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн зөвшөөрүүлэхээр бүх талд илгээнэ.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн дагуу батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг тухайн мэдэгдлийг хүлээн авснаас хойш зургаан (6) сарын дотор талуудын гуравны нэгээс цөөнх

нь хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан хариуг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад өгвөл тухайн нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсгийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн нэмэлт, өөрчлөлтийг бүх талд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан зургаан (6) сар өнгөрснөөс хойш гурван (3) сарын дараа бүх талын хувьд хүчин төгөлдөр болно.

10 дугаар зүйл
Тайлбар хийх

Энэхүү хэлэлцээрийн 13 дугаар зүйлийн 5 дахь хэсгээс бусад аливаа заалтанд үл нийцсэн тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.

11 дүгээр зүйл
Цуцлах

Аливаа тал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар энэхүү хэлэлцээрийг цуцалж болно. Цуцлах тухай мэдэгдэл нь түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан өдрөөс хойш арван хоёр сарын (12) дараа хүчин төгөлдөр болно.

12 дугаар зүйл
Түр цуцлах

Арван хоёр (12) сарын хугацаанд талуудын тоо найм (8)-аас цөөн байгаа тохиолдолд энэхүү хэлэлцээрийг түр цуцалж болно. Ийм тохиолдолд Нарийн бичгийн дарга нарын газар талуудад мэдэгдэнэ. Талуудын тоо найм (8) хүрвэл энэхүү хэлэлцээрийн заалтууд дахин хүчин төгөлдөр болно.

13 дугаар зүйл
Маргаан шийдвэрлэх

1. Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэглэх талаар хоёр буюу түүнээс дээш талын хооронд үүссэн аливаа маргааныг хэлэлцээ хийх буюу зөвлөлдөөний журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд маргалдагч аль нэг талын хүсэлтээр эвлэрүүлэгчээр шийдвэрлүүлэх бөгөөд маргалдагч талуудын харилцан зөвшөөрсний үндсэн дээр сонгосон нэг буюу түүнээс дээш эвлэрүүлэгчид шилжүүлнэ. Ийнхүү хүсэлт гаргаснаас хойш гурван (3) сарын дотор маргалдагч талууд эвлэрүүлэгч буюу эвлэрүүлэгчдийг сонгох талаар тохиролцож чадахгүй бол аль нэг тал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүсэлт гаргаж маргаан шийдвэрлүүлэхээр бие даасан нэг эвлэрүүлэгчийг томилуулж болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу томилогдсон эвлэрүүлэгч буюу эвлэрүүлэгчдийн зөвлөмжийг маргалдагч талууд заавал дагаж мөрдөх албагүй боловч энэ зөвлөмж нь асуудлыг эргэн авч үзэх үндэс болно.

3. Маргалдагч талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр эвлэрүүлэгч буюу эвлэрүүлэгчдийн зөвлөмжийг заавал дагаж мөрдөхөөр урьдчилан хүлээн зөвшөөрч болно.

4. Энэ зүйлийн 1, 2 болон 3 дахь хэсгийн заалтууд нь маргалдагч талуудын харилцан тохиролцсон маргаан шийдвэрлэх бусад арга хэмжээ авахыг хязгаарлахгүй.

5. Аливаа улс соёрхон баталсан батлажм жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орох баримт бичгийг хадгалуулахдаа энэ зүйлийн эвлэрүүлэх асуудлыг тусгасан заалтууд түүний хувьд үйлчлэхгүйг мэдэгдсэн тайлбар хийж болно. Ийм тайлбар хийсэн аливаа талтай холбоотойгоор бусад талын хувьд эвлэрүүлэх асуудлыг тусгасан заалтууд үйлчлэхгүй.

14 дүгээр зүйл
Хязгаарлалтууд

1. Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт аль нэг талыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн заалтууд болон тухайн нөхцөл байдлын шаардлагад нийцсэн өөрийн гадаад болон дотоод аюулгүй байдлыг хангахад шаардлагатай аливаа арга хэмжээ авахыг хязгаарлахгүй.

2. Аливаа тал энэхүү хэлэлцээрт нийцүүлэн Транс-Азийн төмөр замын сүлжээг хөгжүүлэхэд бүх талын хүчин чармайлт гаргана. Гэвч энэхүү хэлэлцээрийн аль ч заалт аль нэг талын зүгээс өөрийн газар нутгаар бараа, зорчигчдийг дамжуулан өнгөрүүлэх үүрэг амлалт авахад албадахгүй.

15 дугаар зүйл
Хавсралтууд

Энэхүү хэлэлцээрийн Хавсралт 1 болон Хавсралт 2 нь тус хэлэлцээрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

16 дугаар зүйл
Нарийн бичгийн дарга нарын газар

Ази, Номхон Далайн Эдийн засаг, нийгмийн комисс энэхүү хэлэлцээрийн Нарийн бичгийн даргын газрыг томилно.

17 дугаар зүйл
Эх хадгалах

Энэхүү хэлэлцээрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

Үүнийг баталж, зохих бүрэн эрх олгогдсон хүмүүс энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хоёр мянга зургаан оны арван нэгдүгээр сарын аравны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хотноо хятад, англи, орос хэл дээр тус бүр нэг эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Хавсралт 1

ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭ

Транс-Азийн төмөр замын сүлжээ нь олон улсын ач холбогдолтой дор дурдсан төмөр замын шугамаас бүрдэнэ.

Транс-Азийн төмөр замын сүлжээний үндсийг бүрэлдүүлж буй улс тус бүрийн шугамуудын эхний болон эцсийн өртөөнүүдийн нэрсийг тодоор харлуулж, бусад өртөөнүүдийн нэрсийг босоо шулуунаар жагсаасан болно. Салаа замуудыг зангилаа өртөөний баруун талд тавьсан. Бусад салаануудыг эхний салаа замын дор үзүүлсэн. Транс-Азийн төмөр замын сүлжээний бүх шугам нь адил тэнцүү ач холбогдолтой.

Хилийн цэг дээр эхлэх буюу дуусах шугамын хувьд түүний эхний буюу сүүлийн өртөөний өмнө, эсхүл ард нь хаалтанд хилийн өртөөний нэр болон шууд холбогдох хөрш орны нэрийг заасан.

Шугам дээр тусгай үүрэгтэй өртөөнүүдийн нэрсийг түүний үүргийн хамт бичмэл үсгээр хаалтанд заасан. Эдгээр үүрэгт:

- (хилийн өртөө);
- (өөр царигтай төмөр замтай холбогдох газар);
- (төмөр замын зангилаа);
- (далайн боомтын өртөө);
- (усан онгоцны терминал) зэрэг багтана.

Замын дутуу хэсгийг [дөрвөлжин хаалтанд] заасан.

Олон улсын стандартын байгууллагын дагуу доод тал нь 20 фут буюу түүнээс дээш урттай чингэлэгтэй ачаа боловсруулдаг терминал өртөөнүүдийг доогуур зураасаар зурж тодруулсан.

ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ШУГАМЫН ЖАГСААЛТ

АРМЕНИ
Аюурум-Ньведи

(Садахло, Гүрж)
Аюурум (хилийн өртөө)
Гюмрю (төмөр замын зангилаа)

Мазис (хилийн өртөө)

Ерасх (хилийн өртөө)
(Белидаг-Ордубад, Азербайжан)
Мегри
Ньведи (хилийн өртөө)
(Агбент, Азербайжан)

Ахурян (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар) - (Догу Капи, Турк)
Ереван-Ижеван (хилийн өртөө) - (Бархударли, Азербайжан)
Гагарин-Мартуни-[Жермук-Капан-Мегри (хилийн өртөө)] – (Маранд, Лалын Бүгд Найрамдах Иран Улс)

АЗЕРБАЙЖАН
Ялама-Беюк-Кесик
(Самур, ОХУ)
Ялама (хилийн өртөө)
Баку (усан терминал) (Лалын Бүгд Найрамдах Иран Улс, Казахстан, ОХУ, Туркменистан дахь Каспийн тэнгисийн боомтууд руу усан онгоцны гарам)

Альят (төмөр замын зангилаа) Али Байрамли (төмөр замын зангилаа) - Астара (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар) - (Астара, Лалын Бүгд Найрамдах Иран Улс)

Али Байрамли (төмөр замын зангилаа) - Агбент (хилийн өртөө) - (Ньюведи-Мегри (хилийн өртөө), Армени-Ордубад-Жулфа (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар) - (Жулфа, Лалын Бүгд Найрамдах Иран Улс)

Акстафа Бархударли (хилийн өртөө) - (Ижеван, Армян)

Беук Кесик (хилийн өртөө)
(Гардабани, Гүрж)

БАНГЛАДЕШ
Дарсана-Гундум
(Гэд, Энэтхэг)
Дарсана (хилийн өртөө)
Ишурди (төмөр замын зангилаа) Абдулпур (төмөр замын зангилаа) - (Сингхабад, Энэтхэг)

Абдулпур (төмөр замын зангилаа) -Парбатипур - Бирол (хилийн өртөө) (Радхикапур, Энэтхэг)

Тонки (төмөр замын зангилаа) Дакка
Акаура (төмөр замын зангилаа) Кулаура-Шахбазпур (хилийн өртөө) -(Махисасан, Энэтхэг)

Читагонг (далайн боомтын өртөө)
Дохазари
[Гундум (хилийн өртөө)
(хилийн өртөө)
Мьянмар]

КАМБОЖ
Пойпет-Сианувил
(Клон Лук, Тайланд)
[Пойпет (хилийн өртөө) [Стеуонг боомт (хилийн өртөө)]
Батден (төмөр замын зангилаа) [Крати (хилийн өртөө) - (Лок Нинх муж, Вьетнам)]

Пномпень (төмөр замын зангилаа)
Сианувил (далайн боомтын өртөө)

ХЯТАД
Алашанку-Льяньюган
(Достик, Казахстан)

Алашанкоу (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар)
Урумчи
Тюрпан (төмөр замын зангилаа) — Каши [(хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) - (Торугарт, Киргизстан)]

Ланжоу
Баожи (төмөр замын зангилаа) — Куньмин (төмөр замын зангилаа) - Шингун (төмөр замын зангилаа) - [Качан (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) - (Митикина, Мьянмар)]
[Шингун-Жинхон (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) - Ботен, Лаос)]
Дали (төмөр замын зангилаа) - [Руэли (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) - (Муз, Мьянмар)]
Кунмин (төмөр замын зангилаа) - Хеку (хилийн өртөө) - (Лао Сай, Вьетнам)
Кунмин (төмөр замын зангилаа) - Нанин (төмөр замын зангилаа) - Гуанжоу (төмөр замын зангилаа)
Нанин (төмөр замын зангилаа) - Хеньян (Бээжин-Шеньжений шугамыг холбоно)
Гуанжоу (Бээжин-Шеньжений шугамыг холбоно)

Шиан
Женжу (төмөр замын зангилаа) — (Бээжин-Шеньжений шугамыг холбоно)
Хижу (төмөр замын зангилаа) — (Тяньжин-Шанхайн шугамыг холбоно)
Лианюнан (далайн боомтын өртөө)

Эрээнхот-Дандон
(Замын-Үүд, Монгол Улс)
Эрээнхот (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар)
Бээжин (төмөр замын зангилаа) — (Бээжин-Шеньжений шугамыг холбоно)
Тяньжин (далайн боомтын өртөө)
Шеньян (төмөр замын зангилаа) — (Манжури-Дальяны шугамыг холбоно)
Дандон (хилийн өртөө)
(Синуйжи, БНАСАУ)

Манжур-Дальян
(Забайкальск, ОХУ)
Манжури (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар)
Харбин (төмөр замын зангилаа) — Суйфен (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) - (Гродеково, ОХУ)

Чанчун (төмөр замын зангилаа) — Тумен (хилийн өртөө) - (Намьян, БНАСАУ)
Шеньян (төмөр замын зангилаа) — (Эрээнхот-Дандоны шугамыг холбоно)
Дальян (далайн боомтын өртөө)

Бээжин-Шеньжен
Бээжин
Женжоу (төмөр замын зангилаа) (Аляшанку-Льянюнань шугамыг холбоно)
Вухань
Хенянь (төмөр замын зангилаа) Нанин (төмөр замын зангилаа) - Пиншиань (төмөр замын зангилаа) - (Дондан, Вьетнам)
Нанин -Кунмин
Гуанжоу (төмөр замын зангилаа) Нанин (төмөр замын зангилаа) - Кунмин Пиншань (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар) - (Дондан, Вьетнам)
Шеньжен

Тяньжин-Шанхай
Тяньжин (далайн боомтын өртөө)
Жинан (төмөр замын зангилаа) Циндао (далайн боомтын өртөө)
Хишу (далайн боомтын өртөө) (Аляшанку-Льянюнань шугамыг холбоно) Нанжин
Шанхай (далайн боомтын өртөө)

БНАСАУ
Синуйжи-Нампо
(Дандон, Хятад)
Синуйжи (хилийн өртөө)
Пхеньян (төмөр замын зангилаа) Нампо (далайн боомтын өртөө) Кэсон
Бондон (хамгийн өмнө зүгийн өртөө)
(Дорасан, БНАСАУ)

Туманьян-Кумгансан
(Хасан, ОХУ)
Тумьянан (төмөр замын зангилаа. хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар) Намьян (хилийн өртөө) - (Тумьянан.
Хятад)
Ражин (төмөр замын зангилаа) Ражин (далайн боомтын өртөө)
Чонжин (далайн боомтын өртөө) Намьян (хилийн өртөө) - (Тумьянан. Хятад)
Чонжин(далайн боомтын өртөө)

Ковон
Вонсан
Хэгьюмган
Онжонгри (хамгийн өмнө зүгийн өртөө)
(Жежин, БНСУ)

ГҮРЖ
Гантьяди-Гардабани
Гантьяди (хилийн өртөө)
Сенаки (төмөр замын зангилаа) Поти (далайн боомтын өртөө)
Сатредиа (төмөр замын зангилаа) Батуми (далайн боомтын өртөө)
Тбилиси (төмөр замын зангилаа) Садахло (хилийн өртөө) - (Аюурум, Армян) [Ахалкалаки (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар) - (Карс, Турк)]

Гардабани (хилийн өртөө)
(Веюк - Кесик, Азербайжан)

ЭНЭТХЭГ
Аттари-Жирибам
(Вага, Пакистан)
Аттари (хилийн өртөө)
Дхандари Калан
Нью Дели (төмөр замын зангилаа)

Матура (төмөр замын зангилаа)-Агра-Нагпур (төмөр замын зангилаа)-Вижайвада (төмөр замын зангилаа)-Ченнай (далайн усан боомтын өртөө)-Жоларпетай (төмөр замын зангилаа)-Мадурай (төмөр замын зангилаа)-Тутикорин (далайн боомтын өртөө)
Матура (төмөр замын өртөө) - Мумбай (далайн боомтын өртөө)

Нагпур (төмөр замын өртөө) - Мумбай (далайн боомтын өртөө)
Нагпур (төмөр замын зангилаа) -Колката (далайн боомтын өртөө)
Вижайвада (төмөр замын зангилаа) - Висахапатнам (далайн боомтын өртөө) - Колката (далайн боомтын өртөө)
Жолапреттай (төмөр замын зангилаа) - Мумбай (далайн боомтын өртөө)
Мадурай (төмөр замын зангилаа) - Рамесварам (усан онгоцны терминал)-(Талайманнар, Шри Ланка)

Канпур (төмөр замын зангилаа)

Раксул (хилийн өртөө) - (Биргунж, Непал)

Мугхалсарай
Ситарампур (төмөр замын зангилаа)
Непал)

Раксул (хилийн өртөө) - (Биргунж,

Колката (төмөр замын зангилаа ба далайн боомтын өртөө)

Халдиа (далайн боомтын өртөө)

Геде (хилийн өртөө)
(Дарсана, Шахбазпур, Вангладеш)
Махисасан (хилийн өртөө)
Бадарпур (хилийн өртөө)
Жирибам (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар)
[(Таму, Мьянмар)]

ИНДОНЕЗИ
Мерак-Баньювангий
Мерак (усан онгоцны терминал)
Жакарта (төмөр замын зангилаа ба далайн боомтын өртөө)

Сукабуми – Падаралан - Сикампек (төмөр замын зангилаа)

Сикампек (төмөр замын зангилаа)

Сиребон (төмөр замын зангилаа) - Семарантаван (далайн боомтын өртөө)
- Сурабаяпасартури (далайн боомтын өртөө)
Прупук (төмөр замын зангилаа) - Пурвокерто – Кроя (төмөр замын зангилаа)

Бандунг
Гедебаг
Кроя (төмөр замын зангилаа) Пурвокерто - Прупук (төмөр замын зангилаа)-
-Сиребон (төмөр замын зангилаа)
Йогьякарта (төмөр замын зангилаа) [Магелан]
Солобалалпан
(төмөр замын зангилаа) Гунди-Семарантаван (төмөр замын зангилаа)
Кертосоно (төмөр замын зангилаа) Вонокромо-Сурабаякота
Малан
Бангил
Баньювангий (усан онгоцны терминал)

[Банда Асе] - Пангкалансусу-Рантупрарат
[Банда Асе]
Пангкалансусу
Медан (төмөр замын зангилаа) Белаван (далайн боомтын өртөө)
Тебинтингий (төмөр замын зангилаа) Сьянтар
Кисаран (төмөр замын зангилаа) Танжунбалай
Рантапрарат [Паякумбу]

Телик Баюур-Муаро
Телик Баюур (далайн усан боомтын өртөө)
Букитпутус (төмөр замын зангилаа) Индарунг
Падан
Любук Алун (төмөр замын зангилаа) Нарас
Падан Панжан
(төмөр замын зангилаа) Букитингий-Паякумбу
Муяаракалабан (төмөр
замын зангилаа) Савалунто
Муаро [Лубуклингау]
Лубукллингго-Панжан
Лубукллингго
Муареним (төмөр замын зангилаа) Танжун Эним
Прабумули (төмөр замын зангилаа) Кертапати
Танжункаран (төмөр замын зангилаа) Тахаран
Панжан (усан онгоцны терминал)

ЛАЛЫН БҮГД НАЙРАМДАХ ИРАН УЛС
Рази-Сарас
(Капиков, Турк)
Рази (хилийн өртөө)
Софиан (төмөр замын зангилаа) Жулфа (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар) - (Жулфа, Азербайжан)

Табриз
Мьяне
Казвин (төмөр замын зангилаа) [Рашт-Бандар-э-Анзали (усан онгоцны терминал)] – Астара (хилийн өртөө болон өөр царигтай төмөр замтай холбогдох газар болон өртөө) - (Астара, Азербайжан) (Азербайжан, Казахстан, ОХУ, Туркменистан дахь Каспийн тэнгисийн боомтууд руу усан онгоцны гарам)

Тегеран (төмөр замын зангилаа)	Кум (төмөр замын зангилаа) - Бадруд (төмөр замын зангилаа) Мейбод-Бафк (төмөр замын зангилаа)-Керман-Захедан (өөр царигтай төмөр замтай холбогдох газар) -Миржавех (хилийн өртөө) - (Кохи Тафтан, Пакистан) Кум (төмөр замын зангилаа) - Арак (төмөр замын зангилаа) - Ахваз (төмөр замын зангилаа - Хорамшахр (далайн боомтын өртөө) [Арак (төмөр замын зангилаа) -Керманшах - Хосрави (хилийн өртөө) - (Ханегхен, Ирак)] Ахваз-Бандар-э-Имам-Хомейни (далайн боомтын өртөө) Бадруд (төмөр замын зангилаа) -Эсфахан Бафк (Сарахас-Бандар-Аббасын шугамтай холбодог)
Гармсар (төмөр замын зангилаа)	Бандар-э-Амирабад (усан онгоцны терминал) (Азербайжан, Казахстан, ОХУ, Туркменистан дахь Каспийн тэнгисийн боомтууд руу усан онгоцны гарам)
Шахруд	
Кашмар (төмөр замын зангилаа)	(Сарахас-Бандар-Аббасын шугамтай холбодог)
Фэрмэн	Машад
Сарахс (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар) (Сарахс, Туркменистан)	

Сарахс-Бандар-Аббас

(Сарахс, Туркменистан)	
Сарахс (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар)	
Фэрмэн (төмөр замын зангилаа)	Машад
Кашмар	
Санган (төмөр замын зангилаа)	[Харат (хилийн өртөө) - (Афганистан)]
Биржанд	
Чадормалу (төмөр замын зангилаа)	Ардакан
Бафк (төмөр замын зангилаа)	(Рази-Миржаве шугамтай холбодог)
Бандар-Аббас (далайн усан боомтын өртөө)	

КАЗАХСТАН
Петропавловск-Достик

(Утьяак, ОХУ)	
Петропавловск (хилийн өртөө)	
Кокештай	
Астана (төмөр замын зангилаа)	Эсиль Тоболь (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) - (Картали, ОХУ)

Тоболь (төмөр замын зангилаа) -Айтек-би- Никельтау-Кандагач (төмөр замын зангилаа) (Семиглавий Марч-Актогай шугамтай холбодог)

Карагандий
Моинтий (төмөр замын зангилаа) Чу (төмөр замын зангилаа)
Актогай (төмөр замын зангилаа) Семипалатинск-Аул (хилийн өртөө) -
Локот, (ОХУ) (Семиглавий Марч-Актогай шугамтай холбодог)

Достик (хилийн өртөө ба өөр цариггай төмөр замтай холбогдох газар)
(Алашанку, Хятад)

Семиглавий Мар-Актогай
(Озинки, ОХУ)
Семиглавий Мар

Уральск (хилийн өртөө)
Илецк 1 (хилийн өртөө) (Оренбург, ОХУ)
ОХУ

Актобе
Кандагач (төмөр замын зангилаа) Никельтау (хилийн өртөө) - (Орск, ОХУ)

Никельтау (хилийн өртөө) - Айтеке-би-Тоболь (төмөр замын зангилаа) - Астана (төмөр замын зангилаа) (Петропавловск-Достик шугамтай холбодог)
Макат (төмөр замын зангилаа) - Ганушкино- (Аксарайская, ОХУ)
Макат (төмөр замын зангилаа) - Бейнью (төмөр замын зангилаа) - Оазис (Каракалпакиа, Узбекистан)

Бейнью (төмөр замын зангилаа) - Актау боомт (усан онгоцны терминал) - (Азербайжан, Лалын Бүгд Найрамдах Иран Улс, ОХУ, Туркменистан дахь Каспийн тэнгисийн боомтууд руу усан онгоцны гарам)

Тьюратам
Кзыл-Орда
Арис (төмөр замын зангилаа) Сари-Агаш (хилийн өртөө)
-(Келес,Узбекистан)

Чимкент

Жамбул
Луговая (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) (Бишкек, Киргизстан)
Чу (төмөр замын зангилаа) Моинти (төмөр замын зангилаа)

Алматы-1
Уштобе
Актогай (төмөр замын зангилаа) (Петропавловск-Достик шугамтай холбодог)
КИРГИЗСТАН
Бишкек 1 - Кочкор

(Луговая, Казахстан)
Аламедин
Балычи
[Кочкор]
[Кочкор –Торугарт]
[Кочкор
Казарман (төмөр замын зангилаа) [тодорхойгүй шугам]-Багиш-Жалал-Абад (төмөр замын зангилаа) (Андижан, Узбекистан)

Торугарт (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар)
(Каши, Хятад)

Узбекистан-Оштай хил залгаа

(Андижан, Узбекистан)
Ош (хилийн өртөө)

ЛАОС
[Танален – Му Гиа]

[(Нонкай, Тайланд)
Танален (хилийн өртөө)
Вьентьян (төмөр замын зангилаа) [Ботен (хилийн өртөө) - (Жинхон, Хятад)]
Такхек (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) [Накхон Фаном, Тайланд]
Му Гиа (хилийн өртөө)
(Му Гиа, Вьетнам)]

[Вантао –Денсаван]
[(Чон Мек, Тайланд)]
Вантао (хилийн өртөө)
Паксе
Саваннакет (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) [(Мухдахан,Тайланд)]
Денсаван (хилийн өртөө)
(Лао Бао, Вьетнам)]

МАЛАЙЗ
Падан Бесар –Жохор Бару

(Падан Бесар, Тайланд)
Падан Бесар (хилийн өртөө)
Букит Мертажам
(төмөр замын зангилаа) Баттерворт (далайн боомтын өртөө)
Сетья Жая

Кажан
Гемас (төмөр замын зангилаа)

Бакаф Бару (төмөр замын зангилаа) - Рантау Панжан (хилийн өртөө) - (Сунгай Колок, Тайланд)
Бакаф Бару - Тумпат

Сегамат
Кемпас Бару
(төмөр замын зангилаа)

Пасир Гудан (далайн боомтын өртөө)
Танжун Пелепас (далайн боомтын өртөө)

Жохор Бару (хилийн өртөө)
(Сингапур)

МОНГОЛ
Сүхбаатар-Замын Үүд
(Наушк, ОХУ)
Сүхбаатар (хилийн өртөө)
Улаанбаатар
Замын Үүд (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар)
(Эрээнхот, Хятад)

МЬЯНМАР
Мандалай-Янгон
Мандалай (төмөр замын зангилаа)

Лашио-[Муз (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) - (Руэли, Хятад)]
Калай-[Таму (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) - (Жирибам, Энэтхэг)]

Баго (төмөр замын зангилаа)

Танпьюзаят (төмөр замын зангилаа) - [Три Пагод Пасс (хилийн өртөө) - (Три Пагод Пасс, Тайланд)]
Танпьюзаят (төмөр замын зангилаа (-Йе

Янгон (далайн боомтын өртөө)

БАЛБА
Биргунж-Энэтхэгийн хил залгаа
Биргунж (хилийн өртөө)
(Раксуль, Энэтхэг)

[Какарвитта-Брахма Мандий]
(Панитанкий, Энэтхэг)
[Канкарвитта (хилийн өртөө)
Брахма Мандий (хилийн өртөө)]
(Танакпур, Энэтхэг)

Жанакпур- Энэтхэгийн хил залгаа
Жанакпур (хилийн өртөө)
(Жаянагар, Энэтхэг)

ПАКИСТАН
Кохи Тафтан-Бага
(Миржаве, Лалын Бүгд Найрамдах Иран Улс)

Кохи Тафтан (хилийн өртөө)	
Далбандин (төмөр замын зангилаа)	[Гвадар (далайн боомтын өртөө)]
Спезанд (төмөр замын зангилаа)	Кветта- Бостан-Чаман (хилийн өртөө) - (Спиндулак, Афганистан)
Рохри (төмөр замын зангилаа)	Хайдерабад (хилийн өртөө)-Карачи (далайн боомтын өртөө) - Кюазим (далайн боомтын өртөө) Хайдерабад (хилийн өртөө) – Мирхупас - Хокропар (хилийн өртөө)
Лодхран (төмөр замын зангилаа)	Шер Шах (төмөр замын зангилаа) - Каневал Фэйсалаабад-Шандара (төмөр замын зангилаа) (Лахор-Пешаварын шугамыг холбодог) Шер Шах – Кундян - Атток (төмөр замын зангилаа) – Пешавар (хилийн өртөө) (Афганистан)
Каневал (төмөр замын зангилаа)	Шандара (төмөр замын зангилаа) Мултан
Лахор (төмөр замын зангилаа)	
Вага (хилийн өртөө)	
(Аттари, Энэтхэг)	
Пешавар –Лахор	
(Афганистан)	
Пешавар (хилийн өртөө)	
Атток (төмөр замын зангилаа)	Шер Шах – Лодхран (Кохи Тафтан - Вага шугамыг холбодог)
Исламабад	
Равалпинди	
Шахдара (төмөр замын зангилаа)	Каневал-Лодхран (Кохи Тафтан-Вага шугамыг холбодог)
Лахор	
БНСУ	
Дорасан-Бусан	
(Бондон, БНАСАУ)	
Дорасан (хамгийн хойд өртөө)	
Сеул	
Сувон	
Дэжеон (төмөр замын зангилаа)	Иксан (төмөр замын зангилаа)-Мокпо (далайн боомтын өртөө) Гваньян (далайн боомтын өртөө)
Дэгу	
Бусан (далайн боомтын өртөө)	
ОХУ	
Бусловская-Москва	
(Ваникала, Финлянд)	
Вусловская (хилийн өртөө)	
Санкт-Петербург (төмөр замын зангилаа)	МГА-Волховстрой-Кошта-Вологда -Котельнич (төмөр замын зангилаа) Екатеринбург (төмөр замын зангилаа)

	Котельнич (төмөр замын зангилаа) (Красное-Находка шугамыг холбодог)
Москва (төмөр замын зангилаа)	(Красное-Находка шугамыг холбодог)
Суземка-Москва	
(Зерново, Украин)	
Суземка (хилийн өртөө)	
Брянск	
Москва (төмөр замын зангилаа)	(Красное-Находка шугамыг холбодог)
Красное-Находка	
(Осиновка, Беларусь)	
Красное (хилийн өртөө)	
Смоленск	
Москва	
Нижний Новгород	
Котельнич (төмөр замын зангилаа)	Санкт-Петербург
Екатеринбург (төмөр замын зангилаа)	Курган-Утяк (хилийн өртөө) - (Петропавловск, Казахстан)
	Челябинск-Карталий (төмөр замын зангилаа ба хилийн өртөө)- (Тоболь, Казахстан)
	Карталий (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) - Орск (төмөр замын зангилаа ба хилийн өртөө)-(Никельтау, Казахстан)
	Орск (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) - Оренбург - (Илецк, ОХУ) -(Актюбинск, Казахстан)
Татарская (төмөр замын зангилаа)	Локот (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) - (Аул, Казахстан)
Новосибирск (төмөр замын зангилаа)	Локот (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) - (Аул, Казахстан)
Красноярск	
Иркутск	
Улан-Удэ	
Заудинск (төмөр замын зангилаа)	Наушки (хилийн өртөө) - (Сүхбаатар, онгол)
Каримская (төмөр замын зангилаа)	Забайкальск (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) (Манжур, Хятад)
Усурийск (төмөр замын зангилаа)	Гродеково (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) -(Суйфен, Хятад)
Барановский (төмөр замын зангилаа)	Хасан (хилийн өртөө ба өөр цариг тай төмөр замтай холбогдох газар) - (Туманьян, БНАСАУ)
Угловая (төмөр замын зангилаа)	Владивосток (далайн боомтын өртөө)
Находка (төмөр замын зангилаа ба төмөр замын зангилаа)	Восточный (далайн боомтын өртөө)
Москва-Самур	
Москва	
Рязань	

Кочетовка (төмөр замын зангилаа)	Ртисево-Саратов-Озинки (хилийн өртөө)- (Семиглавый Мар, Казахстан)
Грязи (төмөр замын зангилаа)	Волгоград Лиски Лихая (төмөр замын зангилаа) Ростов-Краснодарь (төмөр замын зангилаа) Веселое (хилийн өртөө) - (Гантьяди, Гүрж) Краснодарь (төмөр замын зангилаа-Крымская (төмөр замын зангилаа)-Новороссийск (далайн боомтын өртөө) Крымская (төмөр замын зангилаа) –Кавказ (далайн боомтын өртөө ба усан онгоцны терминал)
Волгоград (далайн боомтын өртөө) Аксарайская (төмөр замын зангилаа болон хилийн өртөө) Астрахань	Грязи (Ганушкино, Казахстан) Порт Оля (усан онгоцны терминал) (Азербайжан, Лалын Бүгд Найрамдах Иран Улс, Казахстан,Туркменистан дахь Каспийн тэнгисийн боомтууд руу усан онгоцны гарам)
Махачкала (далайн боомтын өртөө ба усан онгоцны терминал)	(Азербайжан, Лалын Бүгд Найрамдах Иран Улс, Казахстан,Туркменистан дахь Каспийн тэнгисийн боомтууд руу усан онгоцны гарам)
Самур (хилийн өртөө) (Яалама, Азербайжан)	
СИНГАПУР **Вудлэндс-** (Жохор Вару, Малайзи) Вудлэндс (хилийн өртөө)	
ШРИ ЛАНКА **Катарагама-Катьюнайке** [Катарагама Хамбантота Матара] Коломбо (далайн боомтын өртөө) Шри Жаяварденепура Котте Катьюнайке **Коломбо-Талайманнар** Коломбо (далайн боомтын өртөө) Курунегала (төмөр замын зангилаа) Махо (төмөр замын зангилаа) Талайманнар (усан онгоцны терминал)	[Дамбулла] Тринкомали (далайн боомтын өртөө) (Рамесварам, Энэтхэг)
ТАЖИКИСТАН **Нау-Канибадам** (Бекабад, Узбекистан)	

Нау (хилийн өртөө)
Худжанд
Канибадам (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) (Суванабад, Узбекистан)

Пахтаабад-Яанги Базар
(Сарьясья, Узбекистан)
Пахтаабад (хилийн өртөө)
Регар
Душанбе 2
Душанбе 1
Яанги Базар

Хошад-Куляб
(Амузан, Узбекистан)
Хошад (хилийн өртөө)
Курган Туб (төмөр замын зангилаа) Яван
Куляб

ТАЙЛАНД
Нонгхай-Падан Бесар
(Танален, Лаос)
Нонкхай (хилийн өртөө)

Буа Яай (төмөр замын зангилаа)	[Накхон Фанон (хилийн өртөө) - (Такхек, Лаос)] [Мукдахан (хилийн өртөө) - (Саваннакет, Лаос)]
Каен Хой (төмөр замын зангилаа)	Нахонратчазима-Убонратчатани-[Чон Мек -(хилийн өртөө)-(Паксе, Лаос)]
Банпхачи (төмөр замын зангилаа)	Накхонсаван (төмөр замын зангилаа)-Денчай (төмөр замын зангилаа)-Чианмай) [Накхонсаван - Маи Сод (хилийн өртөө) - (Мьянвади, Мьянмар)] [Денчай - Чьянграй-Мае Сай (хилийн өртөө) (Тачилек, Мьянмар)]
Бангкок (төмөр замын зангилаа)	Ладхарабан-Чачонсаоек (төмөр замын зангилаа)-Си Рача (төмөр замын зангилаа)-Као Чи Чан (төмөр замын зангилаа)-Саттахип (далайн боомтын өртөө) Чачоэнсао (төмөр замын зангилаа)-Араньяпрапет-Хлон Лук (хилийн өртөө)-[(Пойпет, Камбож)] Си Рача-Лэмчабан (далайн боомтын өртөө) Као Чи Чан-МапТаПут (далайн боомтын өртөө)
Нон Пла Дук (төмөр замын зангилаа)	Намток-[Три Пагода Пасс (хилийн өртөө)-(Таньюзаяат, Мьянмар)]
Хат Яай (төмөр замын зангилаа)	Сунгай Колок (хилийн өртөө)-(Рантау Панжан, Малайзи)

Падан Бесар (хилийн өртөө)
(Падан Бесар, Малайзи)

ТУРК
Какипуль-Капикой
(Болгар, Европ)
Какипуль (хилийн өртөө)
Истанбул
Эскисехир (төмөр замын зангилаа) — Алаюнт-Баликесир-Измир (хилийн өртөө)
Анкара
Калин (төмөр замын зангилаа) — Самсум (далайн боомтын өртөө)
Сивас
Сетинкая (төмөр замын зангилаа) — Карс (төмөр замын зангилаа)-Догукапи (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар)-(Ахурян, Армян)
[Карс (төмөр замын зангилаа, хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар (Ахалкалаки, Гүрж)]
Малатьяа (төмөр замын зангилаа) — Топпракаль (төмөр замын зангилаа)-Адана-Мерсин (далайн боомтын өртөө)
Топпракаль (төмөр замын зангилаа) -Искендерун (далайн боомтын өртөө)

Татван-Бан (усан онгоцны уулзвар)
Капикой
(Рази, Лалын Бүгд Найрамдах Иран Улс)

ТУРКМЕНИСТАН
Туркменбаши -Чарджев
(Баку, Азербайжан)
Туркменбаши
(усан онгоцны терминал) — (Азербайжан, Лалын Бүгд Найрамдах Иран Улс, Казахстан, ОХУ дахь Каспийн тэнгисийн боомтууд руу усан онгоцны гарам)

Ашгабат
Тенжен
Мари (төмөр замын зангилаа) — Парахат-Сарахс (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар)
(Сарахас, Лалын Бүгд Найрамдах Иран Улс)

Туркменабад (төмөр замын зангилаа ба хилийн өртөө) — Газоджак (хилийн өртөө)-(Питняк-К.П.449, Узбекистан)-Дашовуз-Тахяташ (хилийн өртөө) - (Узбекистан)

(Ходчадавлет, Узбекистан)

УЗБЕКИСТАН
Келес-Ходчадавлет
(Сари-Агаш, Казахстан)
Келес (хилийн өртөө)
Тукумачи (төмөр замын зангилаа) — Озодлик - [Ангрен - Халхобад] - Пап (төмөр замын зангилаа) - Коканд Сырдаринская
Хаваст (төмөр замын зангилаа) — Бекабад (хилийн өртөө) - (Нау-Канибадам, Тажикистан)-Суванабад (хилийн өртөө)-Коканд (төмөр замын зангилаа)-Маргилан-Андижан (хилийн өртөө)-(Ош, Киргизстан)

	Коканд (төмөр замын зангилаа) - Пап(төмөр замын зангилаа)-Наманган
Самарканд Улугбек Навой (төмөр замын зангилаа)	Тинчлик-Учкудук-Нукус-Кунград-Каракалпак (хилийн өртөө) - (Оазис, Казахстан)
Бухара	Карши (төмөр замын зангилаа) - Ташгузар (төмөр замын зангилаа) - (Деханабад -Дарбанд) - Бойсан-Кумкургран (төмөр замын зангилаа) - Сариасья (хилийн өртөө) -(Пахтабад, Тажикистан) Карши (төмөр замын зангилаа) - РЗД 154 (хилийн өртөө) – Талимаржан -Керкичи (төмөр замын зангилаа)-(Келиф, Туркменистан) - Термез (төмөр замын зангилаа) - Галаба (хилийн өртөө)-(Хайртон, Афганистан) Термез (төмөр замын зангилаа)-Кумкургран (төмөр замын зангилаа)-Сарьяасьяа (хилийн өртөө)-(Пахтабад, Тажикистан)
Ходчадавлет(хилийн өртөө) (Туркменабад, Туркменистан)	
ВЬЕТНАМ **Лао Сай-Хошимин Сити** (Хеку, Хятад)	
Лао Сай (хилийн өртөө)	
Дон Ан (төмөр замын зангила)	Куан Триу
Ен Вьен (төмөр замын зангилаа)	(Ханой-Дон Дан шугамыг холбодог)
Гиалам (төмөр замын зангилаа)	Хайфон (далайн боомтын өртөө)
Ханой Тан Ап (төмөр замын зангилаа)	[Му Гиа (хилийн өртөө)-(Лаос)]
Данан	[Вун Ан (далайн боомтын өртөө)]
Хошимин сити (төмөр замын зангилаа)	[Вун Тау (далайн боомтын өртөө)] [Лок Нинх муж (хилийн өртөө)-(Крати Камбож)]
Ханой-Дон Дан Ханой	
Гиалам (төмөр замын зангилаа)	
Ен Вьен (төмөр замын зангилаа)	(ЛаоСай Хо Хошиминсити шугамыг холбодог)
Лим(төмөр замын зангилаа)	Фа Лай (төмөр замын зангилаа)-Халонг (далайн боомтын өртөө)
Кэп (төмөр замын зангилаа)	Халон (далайн боомтын өртөө) Куан Триу
Дон Дан (хилийн өртөө) (Пиншянь, Хятад)	

Хавсралт 2

ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭД ХАМААРАХ УДИРДАХ ЗАРЧМУУД

1. Ерөнхий зүйл

Транс-Азийн төмөр замын сүлжээг хөгжүүлэхэд энэхүү хэлэлцээрийн хавсралт 1-д тодорхойлсон техникийн үзүүлэлтүүдэд хамаарах дараах зарчмуудыг удирдлага болгоно. Талууд эдгээр зарчмыг төмөр замын шинэ хэсэг барих, түүнчлэн одоо байгаа замыг сайжруулах болон шинэчлэхэд аль алинд нь мөрдлөг болгох талаар бүх талын хүчин чармайлт гаргана.

2. Шугамын хүчин чадал

Олон улсын ач холбогдолтой төмөр замын шугамууд нь барааны болон зорчигчдын үр дүнтэй, найдвартай, үр ашигтай тээвэрлэлтийг хангахын тулд зохих хүчин чадлаар хангагдсан байна.

3. Ачааны овор хэмжээ

Транс-Азийн төмөр замын сүлжээ нь НҮБ-ын АНДЭЗНК-ын гишүүн улсуудын олон улсын олон төрөлт тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээг тодорхойлоход чухал бүрэлдэхүүн хэсэг болох тул төмөр замын одоо байгаа шугамыг шаардлагатай тохиолдолд сайжруулах болон шинэ шугамыг байгуулахад ISO-ийн стандартын дагуу доод тал нь 20 фут болон түүнээс дээш урттай чингэлгийг саадгүй тээвэрлэх чадвартай байна.

4. Авцалдан зохицох байдал

Техникийн шаардлага нь олон улсын ач холбогдолтой төмөр замын шугамын дагуу олон улсын бараа, чингэлгийн тэвээрлэлтийг аливаа саадгүй тээвэрлэх бололцоог хангасан байх ёстой. Эл зорилгоор төмөр замын шугамууд болон холбогдох дэд бүтэц болон тоног төхөөрөмж нь нефтийн бүтээгдэхүүн, нүүрс, эрдэс бодисын хүдэр, цемент болон үр тариа зэрэг ачааг хүнд даацын галт тэргээр тээвэрлэх болон шилжүүлэн ачихад олон улсын шаардлагыг хангасан байна.

Талууд нь хөрш зэргэлдээ улсуудын болон олон улсын ач холбогдолтой төмөр замын шугам дайран өнгөрч байгаа бусад улсын техникийн шаардлагыг харгалзан үзэх бөгөөд төмөр замын хоорондын техникийн саад хязгаарыг арилгах болон авцалдан зохицох байдлыг хангахын тулд шугамыг сайжруулахад хүчин чармайлт гаргана.

Төмөр замын царигийн хэмжээ ижил буюу шинээр ижил царигтай зам барих тохиолдолд олон улсын тээвэрлэлтэд хэрэглэж буй хөдлөх бүрэлдэхүүний хоорондоо авцалдан зохицох, тухайлбал тоормосны систем болон холболтын таарч тохирох асуудал чухлаар тавигддаг. Энэ тохиолдолд төмөр замын хил дамжсан үйл ажиллагааг үр ашигтай байлгахын тулд хийн тоормостой болон таарч тохирох холболтын системтэй хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах шаардлагатай.

Лавлагааны зорилгоор, Транс-Азийн төмөр замын сүлжээний царигийн тухай мэдээллийг харуулав. Үүнд:

Транс-Азийн төмөр замын сүлжээний
төмөр замын царигийн өргөн (мм)

1,000	1,067	1,435	1,520	1,676
1. Бангладеш[1] 2. Камбож 3. Лаос 4. Малайз 5. Мьянмар 6. Сингапур[3] 7. Тайланд 8. Вьетнам [4]	Индонези	1.Хятад [2] 2.БНАСАУ 3.БНСУ 4.Лалын Бүгд Найрамдах Иран Улс 5.Турк	1.Армян 2.Азербайжан 3.Гүрж 4.Казахстан 5.Киргиз 6.Монгол 7.ОХУ 8.Тажик 9.Туркмен 10.Узбек	1.Бангладеш 2.Энэтхэг 3.Балба 4.Пакистан 5.Шри Ланка

Транс-Азийн төмөр замын сүлжээнд шинээр элсэх бололцоотой гишүүн улсууд: Япон (1,067 мм өргөн) болон Филиппин (1,067 мм өргөн).

[1].Тухайн улсын төмөр замын зарим хэсэг.
[2]. Мөн (Вьетнамаас болон Вьетнам руу) 1000 мм өргөнтөй шугам оруулах.
[3]. Малайзийн төмөр замын үйлчилгээ.
[4]. Мөн 1,435 мм өргөнтөй ба хоёр 1,000/1,435 мм өргөнтөй давхар шугам оруулах.

5. Чингэлгийн терминалын стандартууд

Олон улсын олон төрөлт тээвэрлэлт нь чингэлгийн үр ашигтай терминалтай байхыг шаарддаг. Транс-Азийн төмөр замын сүлжээний дагуу олон улсын чингэлгийн терминалууд нь:

- гол замын шугамд аль болохоор ойрхон байршилтай байх бөгөөд терминалд орох болон гарахад цаг алдахгүй байх;
- бусад ачих буулгах цэгүүдээс хол зайтай байж, ямар нэгэн зэрэгцээ хөдөлгөөнүүдэд саад учруулахгүй байх;
- автомашинаас төмөр замын тээврийн хэрэгсэлд найдвартай шилжүүлэн ачих явдлыг хангахын тулд автозамын тээвэрт ойрхон чөлөөтэй байх;
- ачаа ачих болон буулгахад маневр хийхэд хангалттай урт замтай байх;
- ISO-ийн стандартын дагуу доод тал нь 20 фут болон түүнээс дээш урттай чингэлгийг ачих, буулгах чадвартай боомтын кран, ачигч, ачаа өргөх болон механик аргаар ачаа боловсруулдаг төхөөрөмжөөр тоноглогдсон байх;
- өргөтгөл хийх бололцоог төлөвлөсөн байх;
- бараанд гаалийн үзлэг хийх барилга байгууламжаар хангасан байх шаардлагатай.

Хая
"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turun_medeelel@parliament.mn
Утас: 262420
Хэвлэлийн хуудас: 40,5
Индекс: 200003